



2026 APR

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГААНЫ ХЭЛТЭС

АГУУЛГА

I. СТАТИСТИКИЙН ТОЙМ	1
II. ГАДААД ЭДИЙН ЗАСАГ	2
2.1. Олон улсын эдийн засгийн нөхцөл байдал	2
2.2. АНУ-ын эдийн засаг	4
2.3. БНХАУ-ын эдийн засаг	4
2.4. Түүхий эдийн зах зээл	5
III. ДОТООД ЭДИЙН ЗАСАГ	7
3.1. Эдийн засгийн өсөлт	7
3.2. Инфляц	9
3.3. Улсын төсөв	10
3.2. Мөнгөний нийлүүлэлт	11
3.4. Гадаад худалдаа	11
3.5. Төлбөрийн тэнцэл, ханш	13

График, хүснэгтүүдийн жагсаалт

График 1 ОУВС-ын эдийн засгийн өсөлт, инфляцын хүлээлт	3
График 2 ОУВС-ын инфляцын төсөөлөл	3
График 3 АНУ-ын инфляц	4
График 4 БНХАУ-ын үнийн индекс	5
График 5 Түүхий эдийн үнэ	6
График 6 Монголын эдийн засгийн өсөлт	7
График 7 Монголын эдийн засгийн таамаглал	8
График 8 Инфляц ба бодлогын хүү	9
График 9 Улсын төсөв	10
График 10 Мөнгөний нийлүүлэлт	11
График 11 Нийт экспорт ба импорт	12
График 12 Экспортын голлох бүтээгдэхүүн	12
График 13 Нүүрсний экспорт	13
График 14 Төлбөрийн тэнцэл	13

Хүснэгт 1 Эдийн засгийн өсөлтөд салбаруудын оролцоо, 2026 оны эхний хоёр сарын байдлаар	7
Хүснэгт 2 Олон улсын байгууллагуудын таамаглал	8

I. СТАТИСТИКИЙН ТОЙМ

ҮЗҮҮЛЭЛТҮҮД	НЭГЖ	ТАЙЛАНТ ХУГАЦАА	ӨМНӨХ ҮЕ	ӨМНӨХ ОНЫ МӨН ҮЕ	ЖИЛИЙН ӨСӨЛТ
УЛИРЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД					
		2025Q4	2025Q3	2024Q4	
Бодит ДНБ	тэрбум төгрөг	34,332	24,251	32,133	6.8%
Ажилгүйдлийн түвшин	%	5.6%	5.5%	5.3%	
Дундаж нэрлэсэн цалин	мянган төгрөг	2,878	2,714	2,672	7.7%
САРЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД					
		2026M3	2026M2	2025M3	
Гадаад худалдааны үзүүлэлтүүд					
Нийт экспорт	сая ам.доллар	4,889	3,046	3,013	62.3%
Зэс	сая ам.доллар	2,188	1,404	930	2.4x
Нүүрс	сая ам.доллар	1,756	1,032	1,279	37.4%
Нийт импорт	сая ам.доллар	2,477	1,576	2,546	-2.7%
Хэрэглээ	сая ам.доллар	749	483	893	-16.1%
Түүхий эд	сая ам.доллар	844	512	901	-6.3%
Аж үйлдвэрлэл	сая ам.доллар	260	170	188	38.3%
Шатахуун	сая ам.доллар	618	408	560	10.4%
Тэнцэл	сая ам.доллар	2,412	1,471	467	5.2x
Түүхий эдийн үнэ					
Зэс	\$/тонн	12,336	13,344	9,710	27.0%
Нүүрс (хилийн)	\$/тонн	68.9	66.4	75.7	-9.0%
Алт	\$/трой унц	4,638	5,279	3,118	48.7%
Газрын тос	\$/баррел	104.0	72.3	69.6	49.4%

ҮЗҮҮЛЭЛТҮҮД	НЭГЖ	ТАЙЛАНТ ХУГАЦАА	ӨМНӨХ ҮЕ	ӨМНӨХ ОНЫ МӨН ҮЕ	ЖИЛИЙН ӨСӨЛТ
САРЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД					
		2026M3	2026M2	2025M3	
Улсын нэгдсэн төсөв					
Төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл	тэрбум төгрөг	-1,360	-720	-352	285.48%
Төсвийн тэнцвэржүүлсэн орлого	тэрбум төгрөг	6,303	3968	6,150	2.49%
Төсвийн нийт зарлага	тэрбум төгрөг	7,663	4688	6,503	17.84%
Мөнгөний бодлого					
M2 нийлүүлэлт	тэрбум төгрөг	49,411	48,061	40,745	21.27%
ХҮИ (C2023)	индекс	122.1	120.7	113.8	7.4%
Бодлогын хүү	%	12%	12%	12%	
Хүү ба ханш					
Ам долларын ханш (Эцсийн)	Төгрөг/\$	3,569	3,566	3,475	2.7%
Төгрөгийн хадгаламж	%	11.84%	11.84%	11.48%	
Валютын хадгаламж	%	3.24%	3.41%	3.0%	
Төгрөгийн зээл	%	17.59%	17.26%	16.95%	
Валютын зээл	%	10.23%	10.12%	11.08%	
Гадаад валютын нөөц					
Нийт	сая ам.доллар	7,188	6,802	4,996	43.9%

II. ГАДААД ЭДИЙН ЗАСАГ

2.1. Олон улсын эдийн засгийн нөхцөл байдал

2026 оны 4 сарын 16-ны өдөр Олон улсын валютын сан “Дэлхийн эдийн засгийн төлөв байдлын тайлан”-гаа танилцуулсан ба Ойрх Дорнодын мөргөлдөөнөөс үүдэлтэйгээр дэлхийн эдийн засгийн ирээдүйн хүлээлтэд орсон өөрчлөлтүүдийн тухай онцлон тусгажээ. Тус тайланд 2026 оны олон улсын эдийн засгийн өсөлт, инфляцаас гадна мөнгө, сангийн бодлогын хүлээлт, худалдааны нөхцөл байдал болон түүхий эдийн зах зээлийн таамаглал, эдгээр хүчин зүйлд нөлөөлж буй гол шалтгаануудыг дэлгэрэнгүй авч үзсэн байна.

А. Дэлхийн эдийн засгийн өсөлт ба инфляц

ОУВС дэлхийн эдийн засгийн 2026 оны өсөлтийн төсөөллөө 3.1 хувь болгон буурууллаа. 2026 оны 1-р сард танилцуулсан тайланд дэлхийн эдийн засгийг 3.3 хувиар өснө гэж үзэж байсан ч Ойрх Дорнодын нөхцөл байдал сунжрах эрсдэл нэмэгдсэнээр эдийн засаг агших эрсдэлийг харгалзаж 0.2 нэгж хувиар өсөлтийн төсөөллөө бууруулжээ. Хөгжиж буй орнуудын хувьд өсөлтийн төсөөллийг 0.3 нэгж хувиар бууруулж 3.9 хувь болгосон ба үүсээд буй хямралд хамгийн их хохирол амсах төлөвтэй байгааг онцлов.

Дэлхийн нийт инфляц 2026 онд 4.4 хувь хүртэл нэмэгдэх төлөвтэй байгааг ОУВС-ийн тайланд дурдсан ба энэ нь 2025 оны инфляцын түвшнээс 0.4 нэгж хувиар, 1-р сарын тайланд дурдсан төсөөллөөс 0.6 нэгж хувиар өссөн дүн юм. Дайны улмаас эрчим хүч, хүнсний үнэ өсөж, инфляцын хүлээлт дахин нэмэгдсэнээр инфляцын буурах хандлага саарах төлөвтэй боллоо.

В. Мөнгөний бодлогын хүлээлт

Дэлхийн тэргүүлэх эдийн засагтай улсуудын мөнгөний бодлого улам бүр ялгарах төлөвтэй байна. АНУ-д инфляцын дарамт аажмаар намжихын хэрээр Холбооны нөөцийн сан бодлогын хүүгээ болгоомжтойгоор бууруулах чиг баримталж, 2027 оны төгсгөл гэхэд холбооны сангийн хүүг ойролцоогоор 3.1 хувийн эцсийн түвшинд хүргэхээр төсөөлж байна. Мөн Евро бүсэд мөнгөний бодлогын төлөв илүү чангарч, 2026 оны турш бодлогын хүүг нийт 50 суурь нэгжээр нэмэгдүүлэхээр байна. Энэхүү алхам нь инфляцын эрсдэлийг хязгаарлах, үнийн тогтвортой байдлыг хангахад чиглэж байна.


С. Төсвийн бодлогын хүлээлт

Хөгжингүй орнуудын төсвийн бодлого дунд хугацаанд аажмаар чангарах төлөвтэй байна. АНУ-д “One Big Beautiful Bill Act”-ийн нөлөөгөөр 2026 онд төсвийн алдагдал нэмэгдэж, нийт өр 2031 он гэхэд ДНБ-ий 142 хувьд хүрэхээр байгаа юм. Евро бүсэд, ялангуяа Германд дэд бүтэц болон батлан хамгаалахын зардал өссөнөөр төсвийн алдагдал тэлж, өрийн түвшин бага хэмжээгээр нэмэгдэхээр байна. Японд мөн төсвийн алдагдал өсөх төлөвтэй бөгөөд төсвийн бодлого 2030 он хүртэл тэлэх чиглэлтэй хэвээр байна.

Харин хөгжиж буй болон шинээр хөгжиж буй зах зээлтэй орнуудын хувьд төсвийн бодлого аажмаар чангарч буй ч улсын өр өссөөр, 2031 он гэхэд дунджаар ДНБ-ий 86 хувьд хүрэх төлөвтэй байна.

График 1. ОУВС-ын эдийн засгийн өсөлт, инфляцын хүлээлт


Эдийн засгийн өсөлтийн төсөөлөл, 2025-2027



Эх сурвалж: ОУВС, Дэлхийн эдийн засгийн төлөв байдал, 4-р сар

График 2 ОУВС-ын инфляцын төсөөлөл

Инфляцын төсөөлөл, 2025-2027



Эх сурвалж: ОУВС, Дэлхийн эдийн засгийн төлөв байдал, 4-р сар

D. Худалдааны бодлогын хүлээлт

АНУ-ын 122-р зүйлийн тарифыг¹ сунгах эсвэл дахин хэрэгжүүлэхээр тооцож, АНУ-ын бодит тарифын дундаж түвшинг 13.5 хувь (2025 оны аравдугаар сард 18.7 хувь байсан)

¹ АНУ-ын 122-р зүйлийн тариф нь 1974 оны АНУ-ын Худалдааны тухай хуулийн заалт юм. АНУ төлбөрийн тэнцлийн өндөр алдагдалд орсон гэж Ерөнхийлөгч үзвэл түр хугацаанд импортод нэмэлт татвар эсвэл квот тогтоох эрх олгодог тухай тусгасан байдаг.

гэж үзжээ. Харин дэлхийн бусад орнуудын АНУ-аас импортлох бараанд ногдуулж буй тарифын түвшин 3.5 хувь хэвээр байна.


2.2. АНУ-ын эдийн засаг

АНУ-ын хувьд Ойрх Дорнодын мөргөлдөөнөөс өмнө бодлогын хүүг бууруулж эдийн засгаа дэмжих бодлого давамгайлж байсан бол мөргөлдөөнөөс шалтгаалж инфляцын дарамт нэмэгдсэнээр бодлогын хүү дахин буурах магадлал багасаад байна. Улмаар АНУ-ын инфляц болон хөдөлмөрийн зах зээлийн нөхцөл байдал эдийн засгийн шийдвэрүүдэд нэн чухал хүчин зүйлс болоод байгаа юм. АНУ-ын инфляц 2026 оны 3-р сард 3.3 нэгж хувь болж өмнөх сараас 0.9 нэгж хувиар өссөн ба энэ нь 2022 оноос хойших хамгийн өндөр сарын өсөлт болж байна. Инфляцын энэхүү огцом өсөлт нь Иранд өрнөсөн зөрчилдөөнтэй холбоотойгоор шатахууны үнэ огцом нэмэгдсэнтэй шууд холбоотой бөгөөд бензиний үнийн өсөлтөөс шалтгаалан эрчим хүчний инфляц 2-р сарын 10.9 хувиас 12.5 хувь болж өссөн нь голлох нөлөөг үзүүлжээ.

График 3 АНУ-ын инфляц

АНУ-ын инфляц

жилийн өсөлтийн хувь



Эх сурвалж: U.S. Bureau of Labor Statistics

Нийт инфляц огцом нэмэгдсэн ч суурь үнийн дарамт харьцангуй тогтвортой хэвээр байна. Хүнс, эрчим хүчний үнийг хассан суурь инфляц жилийн 2.6 хувьтай байгаа нь үнийн өсөлт өргөн хүрээнд тархаагүй байгааг харуулж байна. Цаашдын төлөвийн хувьд 3-р сарын инфляцын өсөлт түр зуурын шинжтэй байх магадлалтай ба эрчим хүчний үнэ өндөр хэвээр хадгалагдвал бусад салбарт дам нөлөө үзүүлэх эрсдэлтэй. Иймд 2026 онд инфляцын жилийн дундаж түвшин ойролцоогоор 4.2 хувь байх хүлээлттэй байна².


2.3. БНХАУ-ын эдийн засаг

2026 оны гуравдугаар сард хэрэглээний үнийн индекс (CPI) жилийн 1.0 хувиар өсөж, хоёрдугаар сарын 1.3 хувиас буурсан байна. Гэсэн хэдий ч гадаад орчны нөлөөллөөс үүдэлтэй өртгийн дарамт үйлдвэрлэлийн түвшинд нэмэгдэж эхэлсэн нь анхаарал татаж байна. Ойрх Дорнод дахь зөрчилдөөнөөс үүдэлтэй нефтийн үнийн өсөлттэй

² АНУ цэвэр эрчим хүч экспортлогч болсон ч дотоодын үнэ дэлхийн зах зээл, боловсруулах хүчин чадал, геополитикийн эрсдэл, хүлээлтийн нөлөөнөөс шууд хамаардаг тул эрчим хүчний инфляц хурдан бөгөөд огцом өсөх боломжтой хэвээр юм.

холбоотойгоор үйлдвэрлэгчийн үнийн индекс (PPI) 2026 оны 3 сард жилийн 0.5 хувиар өсөж, 2022 оноос хойш анх удаа эерэг үзүүлэлтэд хүрлээ. Энэ нь Хятадын эдийн засаг удаан хугацаанд үргэлжилсэн үйлдвэрлэлийн дефляциас аажмаар гарч эхэлж буйг илтгэх боловч дотоод эрэлт сул хэвээр байгаагаас энэхүү өртгийн өсөлт эцсийн хэрэглээний үнэд бүрэн дамжиж амжаагүй байна.

График 4 БНХАУ-ын үнийн индекс



Иймд Хятадын инфляц богино хугацаанд бага түвшинд тогтвортой байх хандлагатай ч, эрчим хүчний үнэ өндөр хэвээр хадгалагдвал дунд хугацаанд инфляц нэмэгдэх төлөвтэй байна.

2.4. Түүхий эдийн зах зээл


2025 оны 4 сараас 2026 оны 4 сар хүртэлх олон улсын зах зээлийн гол 4 түүхий эдийн үнийн өөрчлөлтийг дараах графикт дүрслэв. Ойрх Дорнод дахь мөргөлдөөнтэй холбоотойгоор сүүлийн 1 сарын хугацаанд түүхий эдийн бүтээгдэхүүний үнэ өндөр савлагаатай байна. Алтны үнэ 3-р сарын байдлаар 4,529 ам.доллартой тэнцэж өмнөх сараас 13.3 хувиар буурсан бол газрын тос 101 ам.долларт хүрч 24.3 хувиар өсжээ. Харин олон улсын коксжих нүүрсний зах зээлийн индексийн үнэ 142.4 ам.доллартой тэнцэж байгаа ба энэ нь өмнөх сараас 13.2 хувиар өссөн дүн болж байна. Түүнчлэн зэсийн үнэ 12,223 ам.доллар хүрч өмнөх сараас 8.4 хувиар буурчээ. Ийнхүү мөргөлдөөн хурцдаснаас 1 сарын дараа газрын тосны үнэ өсөхийн хэрээр алтны ханш суларсан бол нөгөөтээгүүр нүүрсний үнэ бага зэргийн өсөлт үзүүлж, зэсийн үнэ суларсан дүр зурагтай байна.

Мөргөлдөөн хурцдаснаар эрчим хүчний нийлүүлэлтийн эрсдэл нэмэгдэж, улмаар газрын тосны үнэ огцом өссөн бол эрсдэлээс зайлсхийх хандлага суларч, долларын ханш чангарснаар алтны үнэ тохиргоо (correction) хийж буурсан байна. Харин коксжих нүүрс нь ган үйлдвэрлэлийн эрэлт болон нийлүүлэлтийн тодорхой тасалдлаас шалтгаалан өсөлт үзүүлсэн бөгөөд эрчим хүчний тасалдлаас үүдэн нүүрсний эрэлт нэмэгдэх төлөв ажиглагдаж байна. Хятадын дотоод эрэлт сул, дэлхийн эдийн засгийн өсөлтийн хүлээлт буурснаас шалтгаалж зэсийн эрэлт суларч үнэ буурах дарамт үүсчээ.

График 5 Түүхий эдийн үнэ

Түүхий эдийн үнэ

2025 оны 4 сар - 2026 оны 4 сар



Эх сурвалж: Bloomberg Terminal

ОУВС-ын 4-р сарын тайланд дурдсан түүхий эдийн үнийн таамаглал: 2026 онд эрчим хүчний түүхий эдийн үнэ 19 хувиар өсөх төлөвтэй байгаа нь 2025 оны аравдугаар сард гаргасан Дэлхийн эдийн засгийн төлөв (WEO)-д тооцоолсонтой харьцуулахад мэдэгдэхүйц өөрчлөлт юм. Ялангуяа Ойрх Дорнодод үйлдвэрлэл болон тээвэрлэлтийн үйл ажиллагаа тасалдсанаас шалтгаалан газрын тосны үнэ 21.4 хувиар өсөхөөр байна. Үүний үр дүнд 2026 оны нефтийн спот үнийн индекс нэг баррель нь дунджаар 82 ам.долларт хүрэх тооцоо гарчээ.

Байгалийн хийн үнэ газрын тосноос илүү их өсөх төлөвтэй байна. Үүний гол шалтгаан нь хийн олборлолт зогссоны дараа дахин эхлүүлэхэд техникийн хувьд илүү хүндрэлтэй бөгөөд нөөцийн хэмжээ харьцангуй бага байдагтай холбоотой юм. Үүнээс гадна эрчим хүч болон бордооны үнэ өсөх, тээвэрлэлтийн зам тасалдах, тээврийн зардал нэмэгдэх зэрэг хүчин зүйлсийн улмаас хүнсний үнэ мөн өсөхөөр байна. Энэхүү өсөлт нь 2025 оны аравдугаар сард хийгдсэн өмнөх төсөөллөөс илүү өндөр байх хандлагатай. Харин суурь болон үнэт металлын үнэ 2025 онд бий болсон өсөлтийн түвшнээ хадгалах төлөвтэй байна.

III. ДОТООД ЭДИЙН ЗАСАГ


3.1. Эдийн засгийн өсөлт

2026 оны эхний хоёр сарын урьдчилсан гүйцэтгэлээр Монгол улсын эдийн засгийн өсөлт 7.6%-д хүрсэн ба энэ нь өмнөх оны мөн үеийн 3.2%-ийн өсөлтөөс үнэмлэхүй сайжирсан үзүүлэлт болж байна.

График 6 Монголын эдийн засгийн өсөлт

Эдийн засгийн өсөлт

жилийн өсөлт (2015 он суурь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Ийнхүү өсөхөд уул уурхай, олборлолтын салбар өмнөх оны мөн үетэй харьцуулахад 32.3%-аар, үйлчилгээний салбар 4.2%-аар өссөн нь голлон нөлөөлжээ. Салбарын оролцооны хувиар авч үзэхэд нийт эдийн засгийн өсөлтийн 5.1 нэгж хувийг уул уурхай, олборлолтын салбар, 2.3 нэгж хувийг үйлчилгээний салбар бүрдүүлсэн бол удаалж 0.4 нэгж хувийг үйлдвэрлэл, барилгын салбар, харин 0.3 нэгж хувийг хөдөө аж ахуйн салбар бий болгожээ³.

Харин бүтээгдэхүүний цэвэр татвар өмнөх оноос 3.7%-аар буурч эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлсөн ба үүнд суудлын автомашины онцгой албан татвар 59.2%, импортын барааны НӨАТ 4.9%-аар тус тус буурсан нь голлон нөлөөлжээ.

Хүснэгт 1 Эдийн засгийн өсөлтөд салбаруудын оролцоо, 2026 оны эхний хоёр сарын байдлаар

ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ, САЛБАРААР	Оролцоо	Жилийн өсөлт
ДНБ	7.6%	
ХАА	0.3%	10.5%
Уул уурхай, олборлолт	5.1%	32.3%
Үйлдвэрлэл, барилга	0.4%	3.3%
Үйлчилгээ	2.3%	4.2%
Бүтээгдэхүүний цэвэр татвар	-0.5%	-3.7%


³ Голлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлээр авч үзэхэд өмнөх оны мөн үеэс нүүрсний олборлолт 46.4%-аар, харин зэсийн баяжмалын үйлдвэрлэл 40.9%-аар өссөн байна.

2026 оны 4-р сард эдийн засгийн өсөлтийн таамаглал шинэчлэгдлээ.

Дотоодын болон олон улсын байгууллагуудын шинэчлэгдсэн таамаглалаар Монгол улсын эдийн засгийн өсөлт 2026 оны эцэст дунджаар 5.4%-д хүрэх бол ирэх жил 5.6% байх хүлээлттэй болж шинэчлэгдлээ. Өмнөх улирлын төсөөлөлтэй харьцуулахад 2026 онд эдийн засгийн өсөлтийн таамаглал ийнхүү ялимгүй буурсан бол ирэх жилийн хувьд нэмэгдээд байна.

График 7 Монголын эдийн засгийн таамаглал

Эдийн засгийн өсөлтийн дундаж таамаглал



Геополитикийн хурцадмал байдлаас шалтгаалсан олон улсын тогтворгүй нөхцөл байдал шатахууны үнээр дамжиж олон улсад төдийгүй манай улсад инфляцыг хөөрөгдүүлэх, улмаар зардлын сувгаар дамжин нийт үйлдвэрлэл саарах, мөн мөнгөний хатуу бодлого үргэлжилснээр эдийн засгийн өсөлт энэ жил харьцангуй тогтворжих хүлээлттэй байгаа юм.

Хүснэгт 2 Олон улсын байгууллагуудын таамаглал

	Сүүлд шинэчлэгдсэн	2026	2027
Монголбанк	2025 Dec	5.8%	5.6%
	2026 Apr	5.5%	6.0%
ОУВС	2025 Oct	5.5%	5.5%
	2026 Apr	5.3%	5.3%
Дэлхийн Банк	2026 Jan	5.9%	5.6%
	2026 Apr	5.0%	5.5%
Азийн Хөгжлийн Банк	2025 Sep	5.7%	5.7%
	2026 Apr	5.7%	6.0%
Голомт Банк	2025 Dec	5.9%	4.7%
	2026 Apr	5.7%	5.3%

Эдийн засгийн өсөлт төлөвийн талаар олон улсын байгууллагуудын байр суурь:

Дэлхийн банк: Дэлхийн зах зээлд эрчим хүчний үнэ өсөж, Ойрх Дорнодын мөргөлдөөнтэй холбоотойгоор геополитикийн тодорхой бус байдал өндөр байгаа ч Монголын эдийн засгийн өсөлт 2026 онд тогтвортой хадгалагдах төлөвтэй байна.


Тодруулбал, уул уурхай болон хөдөө аж ахуй салбар тогтворжиж эдийн засаг 5.0 хувиар өсөх хүлээлттэй байна. Харин уул уурхайн бус салбарын үйл ажиллагааг дэд бүтцийн бүтээн байгуулалт, үйлчилгээний салбар дэмжих төлөвтэй. Өндөр инфляц, цалингийн бага өсөлт, бодлогын хатуу төлөв зэрэг нь хувийн хэрэглээг сааруулах ч, нөгөө талаас төрийн өмчийн байгууллагууд болон Улаанбаатар хотын төслүүд нь төрийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, эдийн засагт гол түлхэц болохоор байна. Хувийн хөрөнгө оруулалт бизнесийн зээлээр дэмжигдэх төлөвтэй ба Оюу толгойн гүний уурхайн бүтээн байгуулалт дууссанаар ГШХО саарах төлөвтэй байна. Дунд хугацаанд дэд бүтцийн томоохон төслүүд болон дотоод эрэлтийн тогтвортой өсөлтийг дагаад, өсөлт дунджаар 5.5 хувь орчим байх төлөвтэй. (Дэлхийн банк, 2026 4-р сар)

Азийн хөгжлийн банк: Ойрх Дорнодод үүсээд буй нөхцөл байдал эдийн засгийн хүлээлтийг муу хувилбарт илүү хазайлгаж байна. Суурь төсөөллөөр эдийн засгийн өсөлт 2026 оны эцэст 5.7%, ирэх жил 6.0%-д хүрч эрчимжих хүлээлттэй ба хүлээгдэж буй төмөр замын төслүүд болон БНХАУ-ын эрэлт хэвээр хадгалагдах зэргээс шалтгаалж нүүрсний олборлолт сайжрах, мөн Оюу Толгойн зэсийн баяжмалын үйлдвэрлэл өсөх хүлээлттэй байгаа зэрэг нь уул уурхайн салбараар дамжиж эдийн засгийн өсөлтийг дэмжих хүлээлттэй байгаа юм. Харин хөдөө аж ахуйн салбар өмнөх жилийн эрчимтэй өсөлтийн дараа хэвийн түвшинд шилжиж эдийн засгийн өсөлтийн 0.5 нэгж хувийг, харин хотын дэд бүтэц, эрчим хүчний томоохон төслүүдийн хэрэгжилтийн үр дүнд үйлдвэрлэл, дэд бүтцийн салбарууд эдийн засгийн өсөлтийн 0.8 нэгж хувийг бий болгох юм. Мөн цаашид уул уурхайн салбарын дам нөлөөллөөр тээврийн салбар сэргэх, аялал жуулчлал нэмэгдэх, гадаад худалдааны аажим сэргэлтийн үр дүнд үйлчилгээний салбарын өсөлт нэмэгдэх зэрэг нь эдийн засгийн өсөлтийг дэмжих хүлээлттэй байна. Харин төрийн үйлчилгээ болон цэвэр татварын өсөлтийн хувь нэмэр дунд хугацаанд саарах хандлагатай байх юм. (Азийн Хөгжлийн Банк, 2026 4-р сар)

3.2. Инфляц

График 8 Инфляц ба бодлогын хүү

Инфляц ба Бодлогын хүү



Эх сурвалж: Монголбанк

Хэрэглээний үнийн индекс (ХҮИ) 2026 оны гуравдугаар сард улсын хэмжээнд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7.4%, өмнөх сараас 1.2%-аар өслөө. Инфляц сүүлийн 4 сар дараалан саарах чиглэлд байсан боловч ийнхүү 3-р сард эргэн эрчимжихэд хүнсний

барааны бүлгийн үнийн өсөлт голлон нөлөөлж нийт инфляцын 3.8 нэгж хувийг бүрдүүлсэн байна.

Цаашлаад жилийн инфляцыг задлан авч үзвэл хүнсний бараа, ундаа, усны үнэ өмнөх оны мөн үеэс 14.1%-иар, боловсролын үйлчилгээний үнэ 12.8%-иар өссөн нь хамгийн өндөр өсөлт боллоо. Харин импортын барааны үнийн өсөлтийн нөлөө өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.6 нэгж хувиар саарч нийт инфляцын 1.9 нэгж хувийг бүрдүүллээ.

Хэдийгээр инфляц төв банкны зорилтот интервалд хадгалагдаж байгаа ч гадаад орчны тодорхой бус байдалтай холбоотойгоор инфляц эргэн өсөх эрсдэлийг харгалзан Монголбанкны Мөнгөний бодлогын хороо 3-р сарын хурлаар бодлогын хүүг хэвээр хадгалахаар шийдвэрлэлээ.

3.3. Улсын төсөв

2026 оны 1-р улиралд улсын төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 1.4 их наяд төгрөгийн алдагдалтай гарлаа. Ийнхүү төсвийн алдагдал нэмэгдэхэд төсвийн нийт зардал өмнөх оны мөн үеэс 17.9%-иар буюу 1.2 их наяд төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлжээ.

Улсын төсвийн зардал өсөхөд урсгал шилжүүлэг өмнөх оны мөн үеэс 213.5 тэрбум төгрөгөөр буюу 7.1%-иар, хөрөнгийн зардал 497.5 тэрбум төгрөгөөр буюу 84%-иар, бараа үйлчилгээний зардал 338.2 тэрбум төгрөгөөр буюу 15.2% -иар тус тус өссөн нь голлон нөлөөлжээ.

График 9 Улсын төсөв

Улсын төсвийн гүйцэтгэл их наяд төгрөг



Эх сурвалж: YCX

Харин төсвийн тэнцвэржүүлсэн орлого 6.3 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 153.1 тэрбум төгрөгөөр буюу 2.5%-иар хувиар өсөв. Төсвийн орлогын өсөлтөд нийгмийн даатгалын орлого 225.5 тэрбум төгрөгөөр (19.0%), НӨАТ 159.7 тэрбум төгрөгөөр (12.8%) өссөн нь голлон нөлөөлсөн байна. Харин орлогын албан татварын орлого 343.5 тэрбум төгрөгөөр (17.0%), онцгой албан татварын орлого 93.3 тэрбум төгрөгөөр (31.6%) тус тус буурсан нь сөргөөр нөлөөлжээ.


3.2. Мөнгөний нийлүүлэлт

2026 оны 3-р сард мөнгөний нийлүүлэлт өмнөх оны мөн үетэй харьцуулахад 21.3%-аар өсөж 49.4 их наяд төгрөгт хүрлээ. Мөнгөний нийлүүлэлт өсөхөд эх үүсвэр (пассив) талаас төгрөгийн хадгаламж болон гадаад валютын харилцах өссөн нь голлон нөлөөлжээ. Тухайлбал, төгрөгийн хадгаламж энэ оны 3-р сард 27.0 их наяд төгрөгт хүрч өмнөх оноос 4.9 их наяд төгрөг буюу 22.1%-иар, валютын харилцах 5.9 их наяд төгрөгт хүрч 67.1%-иар нэмэгджээ. Төгрөгийн хадгаламжийн 81.2 хувийг иргэд, 18.8 хувийг аж ахуйн нэгж, байгууллагын хадгаламж бүрдүүлж байна.

График 10 Мөнгөний нийлүүлэлт

Мөнгөний нийлүүлэлтийн бүрэлдэхүүн хэсгүүд

жилийн өсөлтөд оруулж буй хэмжээ



Эх сурвалж: YCX

Мөнгөний нийлүүлэлтийн өсөлтөд байршуулалт (актив) талаас гадаад валютын цэвэр орох урсгал сайжирч, банкны системийн гадаад цэвэр активын өсөлт нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна. Тухайлбал, гадаад цэвэр актив 2026 оны 3 дугаар сард 10.8 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 5.6 их наяд төгрөгөөр буюу 2.1 дахин өсжээ. Түүнчлэн зээлийн өсөлт өндөр хэвээр хадгалагдсан нь дотоод цэвэр активыг 38.6 их наяд төгрөгт хүргэж, өмнөх оны мөн үеэс 3.1 их наяд төгрөгөөр буюу 8.8%-иар өсөхөд нөлөөлж мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийг мөн дэмжжээ.

3.4. Гадаад худалдаа

2026 оны нэгдүгээр улирлын гүйцэтгэлээр нийт импорт 2,477 сая ам.долларт хүрсэн бол нийт экспорт 4,889 сая ам.долларт хүрснээр гадаад худалдааны тэнцэл өмнөх оны мөн үеэс 5.2 дахин өсөж, 2,412 сая ам.долларын ашигтай гарлаа.

2026 оны эхний улирлын гүйцэтгэлээр экспорт өмнөх оны мөн үетэй харьцуулахад 62.3%-аар өсөхөд зэсийн экспортын орлого 2.4 дахин, харин нүүрсний экспортын орлого 37.4%-аар өссөн нь голлон нөлөөлсөн байна. 2025 оны 4-р улирлаас эхлэн нүүрсний хилийн үнэ тогтворжиж эхэлсэн ба 2026 оны 3-р сарын байдлаар сарын цэвэр үнэ тонн тутамд 68.9 ам.долларт хүрсэн нь 2025 оны 8-р сарын доод түвшнээс даруй 21.3%-аар өссөн үзүүлэлт юм. Мөн 2026 оны эхний улиралд нүүрсний экспортын биет хэмжээ өмнөх оны мөн үеэс 66.8%-аар өсөж 26.3 сая тонн-д хүрснээр экспортын орлого сайжрах эерэг нөлөөллийг үзүүлэв.

График 11 Нийт экспорт ба импорт






График 12 Экспортын голлох бүтээгдэхүүн



Мөн зэсийн баяжмалын экспортын биет хэмжээ эхний улиралд 650.5 мянган тонн, харин хилийн үнийн түвшинд тонн тутамд дунджаар 3,382 ам.долларт хүрснээр өмнөх оны мөн үеэс биет хэмжээ 42.6%, хилийн үнэ 65.0%-аар өсжээ.

Дотоод эрэлтийн идэвхжил өмнөх онуудаас суларч, төгрөгийн ханш харьцангуй тогтворжсоноор хэрэглээний импортын зардал буурч, өмнөх жилүүдэд өсөөд байсан хөрөнгө оруулалтын зориулалттай импорт буурсан зэрэг нөлөөгөөр нийт импортын зардал үргэлжлэн саарч, 2026 оны эхний улиралд импортын нийт зардал өмнөх оны мөн үеэс 2.7%-аар буурчээ.

График 13 Нүүрсний экспорт





3.5. Төлбөрийн тэнцэл, ханш

Сүүлийн саруудад экспортын өсөлт өндөр, харин эсрэгээрээ импортын зардал буурч байгаа нь урсгал дансны алдагдлыг бууруулж, төлбөрийн тэнцэлд эергээр нөлөөлж байна.

2026 оны 2-р сарын хуримтлагдсан дүнгээр урсгал данс 320 сая ам.долларын ашигтай гарсан бол санхүүгийн данс 418 сая ам.долларын алдагдалд хүрч, төлбөрийн тэнцэл 479 сая ам.долларын алдагдалтай гарав. Гэсэн хэдий ч худалдааны тэнцэл үргэлжлэн сайжирч, 2026 оны 3-р сард Засгийн газар 500 сая ам.долларын хэмжээтэй, 5.95%-ийн хүүтэй Сенчири-5 бондыг олон улсын зах зээлд амжилттай арилжаалсан нь санхүүгийн дансаар орж ирэх валютын урсгалыг нэмэгдүүлж, төлбөрийн тэнцэлд эергээр нөлөөлөх хүлээлттэй байна.

График 14 Төлбөрийн тэнцэл





Эх сурвалж: Монголбанк

Хөрөнгийн цэвэр орох урсгал харьцангуй өндөр байж, төв банк дахь алт тушаалт нэмэгдсэн нөлөөгөөр гадаад валютын албан нөөц сайжирч 2026 оны 3-р сард түүхэн дээд хэмжээнд буюу 7.2 тэрбум ам.долларт хүрлээ. Энэ нь өмнөх оны мөн үеэс даруй 44%-аар өссөн үзүүлэлт ба 8.5 сарын нийт импорт, 5.6 сарын бараа болон үйлчилгээний импортын хэрэгцээг хангах түвшин юм. Гадаад секторын төлөв ийнхүү эерэг үзүүлэлттэй байгаа нь төгрөгийн ханш тогтворжих нөхцөлийг бүрдүүлж байна.

Эдийн засгийн цаашдын төлөв харьцангуй тогтвортой байх хүлээлттэй ч гадаад орчны тодорхой бус байдал, ялангуяа Ойрх Дорнод дахь нөхцөл байдал хэрхэн үргэлжлэх нь түүхий эдийн үнэ, импортын зардлаар дамжин төгрөгийн ханш, инфляц болон эдийн засгийн төлөвийг өөрчлөх голлох эрсдэл болж байна.



ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГААНЫ ХЭЛТЭС

☎ 7575-1111 /1277/
✉ eru@golomtbank.com
🌐 www.dua.golomtbank.com

📍 Голомт банкны төв байр,
Сүхбаатарын талбай 5, Ш/х-22,
Улаанбаатар 15160, Монгол Улс
SWIFT: GLMT MNUB

АНХААРУУЛГА

Голомт банкны Эдийн засгийн судалгааны хэлтэс нь Монгол улсын макро эдийн засгийг бүхэлд нь хамарч судалдаг билээ. Энэхүү тайлан нь макро эдийн засгийн хамгийн сүүлийн үеийн өгөгдлийг ашигласан болно. Энэхүү тайланд тусгагдсан агуулга, санаа нь Голомт банкны байр суурийг илэрхийлэх албагүй болно. Голомт банкнаас урьдчилан бичгээр зөвшөөрөл авалгүйгээр энэ тайлангийн аль нэг хэсгийг хуулбарлах, системд хадгалах, ямар нэг хэлбэрээр дамжуулах, цахим механик хэлбэрээр хувилах, бичлэг хийхийг хориглоно.